



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар A/51

Жаргалтхаан

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 48 дугаар зүйлийн 46.2.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 124 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд 2024 онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Сумын төвийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Чинбат – Иргэний танхимын ажилтан

Нарийн бичгийн дарга: М.Ариунжаргал- Иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын ажлын албаны мэргэжилтэн

Гишүүд: Т.Сүрэнцэцэг – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Н.Энхзул – Архив, бичиг хэргийн ажилтан

С.Жавзандулам- Мал эмнэлгийн тасгийн дарга

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулах, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг үнэлгээний хороо (Б.Чинбат)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЦЭНГЭЛ